



---

**МОН-ИТ  
БУЛИГААР ХК**

**ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН МАТЕРИАЛ**

---

**2020 он**

## ХУРЛЫН МАТЕРИАЛЫН АГУУЛГА

1. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ
2. ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ
3. БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА
4. 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТ
5. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ
6. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫН ТӨСӨЛ
7. САНАЛЫН ХУУДАС

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Хурал 2020 оны 04 сарын 20-ны өдрийн  
14:00 цагт эхэлж, 16:00 цагт дуусна.

Хуралд оролцогчдийг бүртгэнэ	14:00-14:10
Бүртгэлийн ажиллагааны дүнг гаргах	14:10- 14:20
Хурлыг нээх	14:20-14:30
2019 оны санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах	14:30-14:50
Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг танилцуулах, сонгох	14:50-15:00
Асуулт, Хариулт, санал хураалт	15:00-15:30
Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах	15:30-15:50
Хурлаас гарсан шийдвэрийг Хурлын дарга танилцуулж хурлыг хаах	15:50-16:00

Хурлын үргэлжлэх хугацаа: 2 цаг

Жич: Шаардлагатай бол хурлын хугацааг сунгаж болно.

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. “Мон-Ит Булигаар” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. “Мон-Ит Булигаар” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд (кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ийг 1 жилийн хугацаагаар улируулан сонгох



## БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

**МОН-ИТ БУЛИГААР ХК НЬ МОНГОЛЫН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТҮҮХИЙГ БИЧИЛЦСЭН, 85 ЖИЛ ХАМТ ХӨГЖИЖ ЯВАА АНХНЫ АРЬС ШИР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ЮМ.**



1934 оны 3 дугаар сарын 26-нд тухайн үеийн ЗХУ-ын хөрөнгөөр "Булигаар завод" нэртэйгээр байгуулагдсан. Арьсыг шохойдох, идээлэх, гүйцэтгэх үндсэн 3 дамжлага бүхий арьс ширийг гүн боловсруулах цехүүдтэй байсан.

1976 онд БНСЧУ-ын тусламжтайгаар тоног төхөөрөмжийг бүрэн шинэчилж жилд 370 мянган ширхэг бодын арьс шир боловсруулах хүчин чадал бүхий шинэ үйлдвэрийг байгуулжээ.

1991 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 17 дугаар тогтоолоор "Булигаарын завод"-ын хувьцааг Монголын Хөрөнгийн биржээр арилжаалсанаар "Булигаар" ХК болж өөрчлөгджээ.

1998 оны 12 дугаар сард Монгол улсын засгийн газрын тогтоолоор, Монгол банк баталгаа гаргаж Итали улсын "Монте Деи Пасчи Сиена" банкны зээлээр Булигаар ХК-ийн үйлдвэрт хөрөнгө оруулалт хийж техник технологийг иж бүрэн шинэчлэж, Монгол улсад мөрдөгдөж буй MNS-4724-2001, MNS60-2001, MNS-86-2002, MNS-5480-2005 стандартаар арьс ширний анхан болон эцсийн боловсруулалт хийдэг орчин үеийн үйлдвэр болсон юм. 2008 оноос Италийн компани хувьцааг нь худалдаж авснаар "Мон-Ит Булигаар" ХК нэртэй болсон бөгөөд Итали технологээр аналин, хагас аналин болон ердийн хром, булигаар, илэг, ус даах чадвар бүхий гутлын материалыг чанар сайтай боловсруулах боломжтой болсон боловч бүрэн хүчин чадлаараа ажиллахгүй, сүүлийн жилүүдэд үйл ажиллагаагаа явуулахгүй сул зогссоноос тоног төхөөрөмж,

барилга байгууламж нь элэгдэлд орж ашиглалтын шаардлага хангахгүй байдалд ороод байсан юм.

2019 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн Хувьцаа Эзэмшигчдийн хурлаар Төлөөлөн Удирдах зөвлөлийг шинээр томилж, ТУЗ байгуулагдсанаас хойш 5 сарын хугацаанд үйлдвэрийн барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмж болон хүний нөөцийн менежментийн шинэчлэлд томоохон хөрөнгө оруулалт хийсэн. Үүнээс:

- ✓ **Барилга байгууламжийн засвар үйлчилгээнд 1,2 тэрбум төгрөг**
- ✓ **Техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд 224 сая төгрөг**

**Нийт: 1,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.**

Бид орчин үеийн шийдэлтэй, ажилтны эрүүл мэнд, тав тухыг хангасан оффис, үйлдвэрийн байрыг ашиглалтанд оруулсан, дотоодын болон гадаадын хэрэглэгчдийн шаардлагад нийцсэн чанартай арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн. Цахилгаан, сантехник, уурын шугам хоолойн иж бүрэн шинэчлэлт, ялтсан дулаан солилцуурын системийг суурилуулсан. Чадварлаг ажилтнуудыг бэдтгэхийн тулд гадаад мэргэжилтнүүдийг урьж ажлын байран дээр сургалт явуулсан. Гадаадад үйлдвэрлэлийн дадлага хийлгэх зэрэг ажлуудыг амжилттай хэрэгжүүлж байна.

Бидний зүгээс дотоодын арьс шир боловсруулах үйлдвэрүүд, арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нартай нэн тэргүүнд хамтран ажиллахыг зорилго болгон ажиллаж байна. Үүний дүнд цэвэр технологид суурилсан, тогтвортой үйлдвэрлэл, түүхий эдийн хаягдлыг бууруулах, мэргэжлийн лаборатори, мэдээлэл судалгааны төв байгуулах, дэлхийн зах зээлд өрсөлдөх, чанартай арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж нээгдэх юм.

Мон-ит булигаар ХК-д үйлдвэрлэсэн арьсаар МУ-ын бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд таатай боломжийг олгож байна.

Химийн боловсруулах цехийн 26 ширхэг барабан дээр бүрэн автоматжуулалт хийгдсэн. Шохойн 8 барабан, хромын 10 барабан дээр 3 ширхэг холигч системийг иж бүрнээр нь шинэчилсэн. Химийн боловсруулах цехийн дулаан хангамжийг сайжруулах зорилгоор улсад үйлдвэрлэсэн 20 ширхэг VOLCANO төхөөрөмжийг суурилуулсан. Химийн боловсруулах цехийн цэвэр ус, халуун ус, дулааны 950 метр шугамыг иж бүрэн

## ҮЙЛДВЭРИЙН ӨРГӨТГӨЛ ШИНЭЧЛЭЛТ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТАЛААР



Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлж махлах болон шахах сунгах машиныг тус бүрийг шинээр суурилуулж өгснөөр өдөрт 300 ширхэг бодын шир, 1000 ширхэг богийн арьс нэмэлтээр боловсруулах боломжтой болсон. Гүүрэн краны механик эд ангиудыг шинэчилж, PLC төхөөрөмжөөр тоноглогдсон инвектор удирдлагатай цахилгаан хөдөлгүүртэй болгож бүрэн автоматжуулсан, электрон жин суурилуулснаар ачааны даац хэтрэлтийг бүрэн хянаж, аюулгүй өргөлт хийх боломжтой болсон.




## ДЭД БҮТЭЦ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, АЖИЛЛАХ ОРЧИН САЙЖРУУЛАХ ТАЛААР:



Үйлдвэрийн барилгын 7200 м<sup>2</sup> дээврийг бүрэн хуулж, шинээр цутгалт хийж ус чийгийг тусгаарлах PVC мембран дээвэр хийсэн. Үйлдвэрийн барилгын гадна фасадны 1700м<sup>2</sup> талбайг хөөсөн хавтангаар бүрж дулаалсан. Үйлдвэрийн барилгын 500 ширхэг цонхыг шинээр сольсон. Гадна инженерийн шугам хоолойг бүрэн шинэчилж 219мм-ийн голчтой 250 метр шугам, 89мм-ийн голчтой 130 метр шугам хоолой болон хучилтын бетон хавтангуудыг тус тус шинээр сольсон. Үйлдвэрийн дулаан хангамж, хэрэглээний халуун усыг тэжээх хүчин чадалтай 2 ширхэг ялтаст дулаан солилцуурыг иж бүрнээр нь суурилуулснаар уур, ус, дулааны зардлаа хэмнэх, мөн түүнчлэн ажилтнууд дулаахан тав тухтай орчинд ажиллах боломжтой болсон. Цэвэр, бохир ус, халаалтын шугам хоолой, халаагуурыг бүрэн шинэчилж, стандартын шаардлага хангасан ариун цэврийн өрөөний тоноглолуудыг суурилуулсан.

Барилгын 6-р давхарын 2200м<sup>2</sup> талбайг орчин үеийн стандартыг хангасан оффис болон үйлдвэрлэлийн зориулалтаар бүрэн засварлаж ашиглалтанд оруулсан. Барилгын 2-р давхарын 900м<sup>2</sup> талбайг оффисийн зориулалтаар засварлаж, ажилтнуудын тав тухыг бүрэн хангасан тавилга тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон оффисийн өрөөнүүд, хурал болон сургалтын өрөө, цай кофений хэсэгтэй, тааламжтай орчинг бүрдүүлэн ажиллаж байна. Барилгын 1-р давхарын 900м<sup>2</sup> талбайг нэг ээлжиндээ 150-200 хүн хоолох хүчин чадал бүхий Ажилтнуудын цайны газар, стандартын шаардлага хангасан хуурай хүнс хадгалах агуулах, VIP хоолны танхим, бэлэн бүтээгдэхүүн борлуулах дэлгүүрийн зориулалтаар иж бүрэн засаж тохижуулан ашиглалтад оруулав. Хятад улсын HSEE брэндийн 1000кг даац бүхий зорчигчийн липтийг шинээр суурилуулж, ашиглалтад оруулав.

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ ЗАСВАРЛАЖ, АШИГЛАЛТАНД ОРУУЛСАН**





**ДУЛААНЫ ШУГАМ СҮЛЖЭЭГ ИЖ БҮРНЭЭР НЬ СОЛЪЖ ШИНЭЧИЛСЭН**



## ОФФИСЫН ХЭСГИЙГ ТОХИЖУУЛЖ АШИГЛАЛТАНД ОРУУЛСАН



## АЖИЛТНУУДЫН ЦАЙНЫ ГАЗРЫГ ЗАСВАРЛАЖ АШИГЛАЛТАНД ОРУУЛСАН





## ТОНОГ ТӨХӨӨРӨМЖҮҮДИЙГ ЗАСВАРЛАЖ, ШИНЭЧИЛСЭН





## ГАДНА ТАЛБАЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭЖ ТОХИЖУУЛСАН



## 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
А.ЭНХМЭНД

“МОН-ИТ БУЛИГААР” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2019 оны зорилтуудын талаарх илтгэлийг Компанийн тухай хууль, МОН-ИТ БУЛИГААР ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

МОН-ИТ БУЛИГААР ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус компанийн 2019 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа компаний засаглалын кодексийг баримталж, бусад холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдлөг болгож, Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр зөвлөмж, төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаа.

2019 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийг шинээр томилж, ТУЗ байгуулагдсанаас хойш 5 сарын хугацаанд үйлдвэрийн барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмж болон хүний нөөцийн менежментийн шинэчлэл зэрэгт нийт 1.4 тэрбум төгрөгийн томоохон хөрөнгө оруулалт хийсэн.

Булигаарын үйлдвэрийн Нойтон арьс боловсруулах цех болон Хуурай арьс боловсруулах цехийн тоног төхөөрөмжүүдийг автоматжуулж бодын арьсны махлах, хуваах машинд 100 хувь капитал засвар хийсэн бөгөөд богийн арьсны индүү, махлах машин зэргийг шинээр худалдан авч сайжруулсан.

Бидний зүгээс дотоодын арьс шир боловсруулах үйлдвэрүүд, арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нартай нэн тэргүүнд хамтран ажиллахыг зорилго болгон ажиллаж байна. Үүний дүнд цэвэр технологид суурилсан, тогтвортой үйлдвэрлэл, түүхий эдийн хаягдлыг бууруулах, мэргэжлийн лаборатори, мэдээлэл судалгааны төв байгуулах, дэлхийн зах зээлд өрсөлдөх, чанартай арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж нээгдэх юм.

Оффисын барилга байгууламжийг 100 хувь ашиглалтанд оруулж үйл ажиллагаагаа жигдрүүлэн ажиллаж байна.

2019 оны 05 сард 36 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байсан бөгөөд 2020 оны 03 дугаар сарын байдлаар нийтдээ 71 ажилтантай болж өргөжсөн

Олон улсын нэр хүнд бүхий Испани, Франц, Орос, Хятад улсуудын мэргэжлийн технологич нараас туршлага солилцож бод болон богийн арьс ширийг чанартай боловсруулах технологи аргазүйг судлах ажлыг хийж эхлэн үйл ажиллагаандаа нэвтрүүлж байна.



“Мон-Ит булигаар” ХК 2019 оны сүүлийн хагас жилд үйл ажиллагаагаа тогтвортой явуулж эхэлсэнээс хойш 609 сая төгрөгийн борлуулалт хийсэн ба 2018 оны мөн үеэс 76 хувиар өсөлттэй байна.

Мөн тайлант жилд 954 510 тонн буюу 56 700 ширхэг арьс шир боловсруулж, нийт 1,2 тэрбум төгрөгийг барилга байгууламжийн бүтээн байгуулалт, 224 сая төгрөгийг үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтад зориулсан байна.

Иймд “Мон-Ит Булигаар” ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2019 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс дүгнэж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  А.ӨНХМЭНД



**САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

	1-р сарын 1 /Төгрөгөөр/	12-р сарын 31 /Төгрөгөөр/
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,570,681	28,178,477
Дансны авлага	2,275,848,535	1,879,387,580
Бусад авлага	-	83,189,367
Бараа материал	743,731,900	2,508,678,676
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>3,021,151,116</b>	<b>4,499,434,099</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	8,831,226,100	9,982,440,911
Биет бус хөрөнгө	1,655,802,500	1,655,802,500
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>10,487,028,600</b>	<b>11,638,243,411</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>13,508,179,716</b>	<b>16,137,677,510</b>
Дансны өглөг	1,371,126,916	1,770,304,860
Татварын өр	56,620,700	86,554,970
ЭМНД -ийн шимтгэлийн өглөг	104,529,100	75,358,995
Богино хугацаат зээл	3,339,999,900	2,498,202,591
Хүүний өглөг	61,572,100	31,603,734
Урьдчилж орсон орлого		124,584,250
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>4,933,848,716</b>	<b>4,586,609,401</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
Урт хугацаат зээл		3,620,663,069
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>3,620,663,069</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>4,933,848,716</b>	<b>8,207,272,470</b>
<b>Эздийн өмч</b>		
Өмч :		
в) хувьцаат	40,021,200	40,021,200
Халаасны хувьцаа	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,939,092,300	4,939,092,300
Эздийн өмчийн бусад хэсэг	266,001,000	266,001,000
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	3,329,216,500	2,685,290,540
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>8,574,331,000</b>	<b>7,930,405,040</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>13,508,179,716</b>	<b>16,137,677,510</b>

**ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

	<b>1-р сарын 1</b> <b>/Төгрөгөөр/</b>	<b>12-р сарын 31</b> <b>/Төгрөгөөр/</b>
<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	347,388.7	<b>609,735,570.54</b>
Борлуулалтын өртөг	256,967.2	486,901,335.53
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	90,421.5	<b>122,834,235.01</b>
Түрээсийн орлого	0.0	19,824,023.89
Хүүний орлого	0.0	14,967.54
Бусад орлого	219,000.8	45,047,874.23
Борлуулалт, маркетингийн зардал	485,843.7	
Ерөнхий ба удирдлагын зардал	0.0	606,846,001.30
Санхүүгийн зардал	0.0	-
Бусад зардал	28,162.7	118,683,617.63
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.0	(126,234,438.35)
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	-204,584.1	<b>(664,042,956.61)</b>
Орлогын татварын зардал	0.0	<b>1,496.75</b>
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	-204,584.1	<b>(664,044,453.37)</b>
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	-204,584.1	<b>(664,044,453.37)</b>
<b>Орлогын нийт дүн</b>	-204,584.1	<b>(664,044,453.37)</b>

**ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

<b>Үзүүлэлт</b>	<b>Халаасны хувьцаа</b>	<b>Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл</b>	<b>Эздийн өмчийн бусад хэсэг</b>	<b>Хуримтлагдсан ашиг</b>	<b>Нийт дүн</b>
<b>2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	40,021,200	4,939,092,300	266,001,000	3,329,216,500	8,574,331,000
<b>2019 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл</b>	<b>40,021,200</b>	<b>4,939,092,300</b>	<b>266,001,000</b>	<b>3,329,216,500</b>	<b>8,574,331,000</b>
Залруулсан үлдэгдэл	40,021,200	4,939,092,300	266,001,000	3,329,216,500	8,574,331,000
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(664,044,453)	(664,044,453)
Өмчид гарсан өөрчлөлт				<b>20,118,494</b>	20,118,494
<b>2019 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>40,021,200</b>	<b>4,939,092,300</b>	<b>266,001,000</b>	<b>2,685,290,540</b>	<b>7,930,405,040</b>

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**


<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>650,063,621.63</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	552,963,581.18
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	4,418,039.33
Буцаан авсан албан татвар	1,385,600.00
Бусад мөнгөн орлого	91,296,401.12
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>6,079,521,645.76</b>
Ажиллагчдад төлсөн	344,409,531.87
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	29,410,970.58
Бараа материал худалдан авахад төлсөн	5,173,726,278.21
Ашиглалтын зардалд төлсөн	313,914,583.09
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	31,878,876.39
Татварын байгууллагад төлсөн	6,928,994.25
Бусад мөнгөн зарлага	179,252,411.36
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(5,429,458,024.13)</b>
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>14,967.54</b>
Хүлээн авсан хүүний орлого	14,967.54
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>6,268,036.36</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,268,036.36
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>(6,253,068.82)</b>
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>5,541,095,163.00</b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	5,541,095,163.00
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>77,253,957.58</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	77,253,957.58
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>5,463,841,205.42</b>
Валютын ханшийн зөрүү	(1,522,316.47)
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>26,607,796.00</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>1,570,680.77</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>28,178,476.77</b>



## “ДАБЛЬ АКСИОМ АУДИТ”

ХХК

Аудит, нягтлан бодох бүртгэл,  
аутсоринг, санхүүгийн зөвлөгөө  
үйлчилгээний итгэмжлэгдсэн  
байгууллага



## “DOUBLE AXIOM AUDIT”

LLC

Audit, accounting, outsourcing,  
certified organization of financial  
consulting and service

2020 оны 03 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар. 2020/100

Улаанбаатар хот

## “МОН-ИТ БУЛИГААР” ХК -ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

## ДҮГНЭЛТ

Бид 2019 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “МОН-ИТ БУЛИГААР” ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд “МОН-ИТ БУЛИГААР” ХК -ийн 2019 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв, материаллаг алдаагүй үнэн зөв, шударгаар, толилуулж тайлагнасан байна.

## Дүгнэлтийн Үндэслэл


Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт тусгасан болно. Бид санхүүгийн тайлангийн аудитад хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу танай компаниас хараат бусаар ажилласан бөгөөд Ёс Зүйн Дүрэмд заасан шаардлагуудад нийцүүлсэн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт, нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай хэмжээний зохистой үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

## Аудитын Гол Асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Бидний хийсэн аудитын ажилд аудитын гол асуудал бол компани нь цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулж нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг алдагдуудахгүй байх нь чухал юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Чингэлтэй дүүрэг 3-р хороо,  
Peace tower 17 давхарт 1708 тоот

Утас: 99999956, 99999957  
Вэб сайт: [www.nyagtlan.mn](http://www.nyagtlan.mn)





### Санхүүгийн тайлан болон Аудиторын тайлангаас бусад мэдээлэл

Санхүүгийн тайлангаас бусад мэдээллийн үнэн зөв байдалд компанийн удирдлага хариуцлага хүлээх ба компани нь жилийн тайландаа бусад мэдээллийг ил тодоор илэрхийлэх үүрэгтэй байдаг. Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй тул бид бусад мэдээлэлд баталгаажуулалт гаргахгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай эсвэл аудитын явцад олж авсан бидний ойлголттой нийцэж байгаа эсэх эсвэл материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болзошгүй эсэхийг тодорхойлох явдал юм.

### Удирдлага болон засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.


Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх этгээд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага


Санхүүгийн тайлан нь залилан болон алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин буй материаллаг буруу илэрхийллийг илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан болон алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг хэмжээнд тооцогддог.

Санхүүгийн тайлангийн аудитаар хүлээсэн аудиторын үүрэг хариуцлагын бусад хэсгийг Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтын [www.monicpa.mn](http://www.monicpa.mn) цахим хаягийн стандарт цэсэнд байрлах Аудит Баталгаажуулалтын Олон Улсын Стандартаас татан авч харна уу.

ХҮНДЭТГЭСЭН,



ДАБЛЬ АКЦИОМ  
АУДИТ ХХК



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД НЭР ДЭВШИГЧИД ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ НАМТАР

1. Батчулуун АНХБОЛД “Мон-Ит Булигаар” ХК, Гүйцэтгэх захирал
2. Батчул
3. уун БАЯНЖАРГАЛ “Дархан Минж” ХХК, Гүйцэтгэх захирал
4. Довжид ГАНСҮХ “Мон-Ит Булигаар” ХК, Үйлдвэр хариуцсан захирал
5. Анхболд ЭНХМЭНД “Екап” ХХК, Хөрөнгө оруулалт хариуцсан захирал
6. Мэндбаяр БАТ-ОЧИР “Мон-Ит Булигаар” ХК, Үйлдвэрлэлийн зөвлөх

## ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ НАМТАР

1. Базар АЮУШ “Райнос ассет менежмент Монгол” ХХК, Ахлах аудитор
2. Норолхоожав БАТХУЯГ “МХС” ТӨХК газрын захирал
3. Нүрэнзэд МЯГМАРДОРЖ “Пример Инвестмент Групп” ХХК, Гүйцэтгэх захирал
4. Цэнд-Аюуш БАЯРСАЙХАН. “ШУТИС”-н Механик Тээврийн Сургуулийн Механик, Мехатроникийн салбарт дэд профессор

### 1. Батчулуун АНХБОЛД

*Худалдааны эдийн засагч, Мэдээлэл зүйч*

#### *Боловсрол*

1990-1994 онуудад Бакалавр, Худалдааны эдийн засагч

1995-1996 онуудад Магистр, Мэдээлэл зүй , Монгол Улсын Их Сургууль

#### *Хөдөлмөр эрхлэлт*

1994-1996 онуудад Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуульд Мэдээлэл зүйн багш

1998-2000 онуудад “Санком” ҮЦК ХХК-ийн Диллер

2001-2005 онуудад “Дархан Минж” ХХК, Ерөнхий захирал

2006-2010 онуудад “Дархан Минж” ХХК, Гүйцэтгэх захирал

2010-2018 онуудад “Дархан Минж” ХХК, Гүйцэтгэх захирал

2019-одоо “Мон-Ит Булигаар” ХК, Гүйцэтгэх захирал

### 2. Батчулуун БАЯНЖАРГАЛ

*Эдийн засагч*

#### *Боловсрол*

1996-2000 онуудад Бакалавр, Эдийн засаг, Монгол Улсын Их Сургууль

#### *Хөдөлмөр эрхлэлт*

2000-2006 онуудад Монгол шуудан банк, Нягтлан бодогч

2006-2010 онуудад “Дархан Минж” ХХК, Гүйцэтгэх захирал

2010- одоо “Дархан Минж” ХХК, Гүйцэтгэх захирал

### 3. Довжид ГАНСҮХ

---

*Барилгын технологич*

#### *Боловсрол*

1986-1991 онуудад Бакалавр, Барилгын технологич, Барилгын Их Сургууль, Эрхүү

#### *Хөдөлмөр эрхлэлт*

1993-1995 онуудад “ТТҮБ траст” ХХК, Барилгын даамал

1995-2004 онуудад “Зэндмэнэ инвест” ХХК, технологич

2004-2008 онуудад “Дархан Минж” ХХК Үйлдвэрлэлийн менежер

2010-2013 онуудад “Дархан Минж” ХХК, Үйлдвэрлэл хариуцсан захирал

2014-2018 онуудад “Сүлд Ивээл Констракшн” ХХК, Захирал

2019-одоо “Мон-Ит Булигаар” ХК, Үйлдвэрлэл хариуцсан захирал

### 4. Анхболд ЭНХМЭНД

---

*Хөрөнгө оруулалтын Санхүүч*

#### *Боловсрол*

2013-2016 онуудад Шинжлэх ухааны Бакалавр, Санхүү ба Менежмент, Вестминстерийн Их Сургууль, Лондон, ИБУИНВУ

2018 онд Хөрөнгө оруулалтын зөвлөхийн ажил үйлчилгээ үзүүлэх эрх

#### *Хөдөлмөр эрхлэлт*

2016-2017 онуудад “Монголын үнэт цаасны бирж” Төв клиринг, ХХК Төлбөр тооцооны ахлах ажилтан

2017 онуудад “Ард секюритиз” ҮЦК ХХК, Хөрөнгө оруулалтын аналит “Миний анхны амжилттай хөрөнгө оруулалт” номын зохиолч

2018 онуудад Үхрийн шир болон бог малын арьсыг гүн боловсруулах экспортын чиг баримжаатай үйлдвэрийн “МОНГОЛ ШИР” ТӨСӨЛ “ПАРК ТАУН” Бонд төсөл, Санхүүгийн зөвлөх

2018-2019 онуудад “Екап” ХХК, Үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулалт хариуцсан захирал

## 5. Мэндбаяр БАТ-ОЧИР

*Арьс ширний үйлдвэрийн инженер технологич, химич*

### *Боловсрол*

1971-1976 онуудад ЗХУ-ын Киев хотын Хөнгөн үйлдвэрийн технологийн дээд сургууль

2004 онд Монгол улсын зөвлөх инженер

*Судалгаа Шинжилгээний ажил*

1995-2004 онд Булигаар ХК-ний техник, технологийг иж бүрэн шинэчлэх төсөл. Үр дүнд 17.0 сая ам.доллараар тус компаний техник, технологийн шинэчлэлтийг удирдан хийлгэж олон улсын жишигт хүрсэн үйлдвэрийг байгуулсан.

Сарлагын ширийг үстэй нь боловсруулах судалгаа, техник технологийн шийдэл. Үр дүнд сарлагын шир үстэй нь боловсруулах цех байгуулан ажиллуулав

Энзим ашиглаж арьсны үс суларуулах техник, технологийн шийдэл Технологийн бохир усны гарцын норм тогтоох судалгааны ажил.

Үр дүн нь Арьс ширний боловсруулалтад хэрэглэсэн цэвэр усны 80 хувь нь бохир ус болох норм тогтоосоноор олон жил арьс ширний салбарт мөрдөгдөж байна.

2004 онд Сур, гутлын улны хөх шир боловсруулах жижиг үйлдвэрийн төсөл

Гоёлын гутлын дээд биений материал үхрийн боловсруулсан арьсны чанар, гарцыг сайжруулах шинжлэх ухаан технологийн төсөл

Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт ҮТ Парк байгуулах ТЭЗҮ Арьс ширний салбарын боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн стратеги зөвлөмж

2008 онд Монгол улсын арьс ширний салбарын 2008-2020 онд хөгжүүлэх стратеги судалгааны ажил

Арьс ширний салбарын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийг тогтоох судалгааны ажил

Арьс ширний үйлдвэрүүдийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийхэд баримтлах чиглэл гарын авлага

2009 онд Арьс ширний үйлдвэрүүдэд хэрэглэдэг химийн бодисын эрсдлийн үнэлгээний мэргэжлийн заавар

Арьс шир боловсруулах жижиг, дунд үйлдвэрийн бохир ус цэвэр-шүүлэх бага оврын цэвэрлэх байгууламжийн ТЭЗҮ-ийн жишиг загвар

2012 онд Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах бүс нутгийн хэмжээний аж үйлдвэрийн цогцолборуудыг байгуулж хөгжүүлэх оновчтой байршлыг тогтоох ТЭЗҮ

Аж үйлдвэр, технологийн парк, шинэ суурьшлын бүсийн ТЭЗҮ

2011 онд Хөнгөн үйлдвэрийн салбарт мөрдөгдөж байгаа стандартын судалгаа, олон улсын стандарт нэвтэрүүлэх боломж судалгааны ажил

2014 онд Арьс ширний үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн ТЭЗҮ

2015 онд Эмээлт Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургын даалгавар

2016 онд Эмээлт хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн технологийн түвшний үнэлгээ хийх сэдэвт ажил.

## 6. Базар АЮУШ

*Эдийн засгийн ухааны дэд доктор*

### *Боловсрол*

1971-1975 онуудад Худалдааны нягтлан бодогч, эдийн засагч, МУИС

1988-1992 онуудад Эдийн засгийн ухааны дэд доктор, Ph.D, Москва Оросын эдийн засгийн академи

2010-2013 онуудад Эрх зүйч, Түшээ дээд сургууль

1995, 2009 онд Үнэт цаасны зах зээлийн хяналт, зохицуулалт, АНУ ҮЦХороо

2005 онд Үнэт цаасны зах зээлийн хяналт, зохицуулалт, Японы Санхүүгийн хяналтын газар

2002 онд Төрийн санхүү, мөнгөний бодлого, Сингапур дахь Дэлхийн банкны сургалтын төв

### *Хөдөлмөр эрхлэлт*

1975-1977 онуудад ТТХЕГ, Орлогч НЯ-БО

1977-1995 онуудад МУИС, Багш

1995-2006 онуудад Үнэт цаасны хороо, Хэлтсийн дарга

1992 онд Эргэлтийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах асуудал /Эрдэм шинжилгээний бүтээл/

2006-2010 онуудад Санхүүгийн зохицуулах хороо, Газрын орлогч дарга

2016 онд Орлогод тохирсон орон сууцны зээлийн зах зээлийн хөгжүүлэх асуудал / судалгааны тайлан/

2010-одоо Зөвлөх профессор, Мандах бүртгэл дээд сургууль

2019-одоо Ахлах аудитор, “Райнос ассет менежмент Монгол” ХХК

## 7. Норолхоожав БАТХУЯГ

---

### *Боловсрол*

1991-1995 онуудад Бакалавр, Зах зээлийн коллеж

1998-1999 онуудад Төрийн удирдлага, Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институт

2018-2019 онуудад Магистр, Бизнесийн удирдлага, Худалдаа аж үйлдвэрлэлийн их сургууль

### *Хөдөлмөр эрхлэлт*

1996-2000 онуудад Тон тен клубт менежер

2000-2006 онуудад Байгаль орчны яам мэргэжилтэн

2007-2012 онуудад Сүхбаатар дүүргийн ЗДТГ хэлтсийн дарга

2013-2016 онуудад LSM ХХК гүйцэтгэх захирал

2016-одоо МХС ТӨХК газрын захирал

## 8. Нүрэнзэд МЯГМАРДОРЖ

---

### *Бизнес удирдлага*

### *Боловсрол*

2001-2004 онуудад Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль, Технологич

2008-2010 онуудад Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль, Бизнесийн удирдлага

2014 онд БНСУ-ын ажиллах хүчний мэргэшсэн сертификат

### *Хөдөлмөр эрхлэлт*

2004-2007 онуудад “Манука” ХХК-д хүнсний технологич

2010-2013 онуудад БНСУ-д ажиллаж байсан

2013-2015 онуудад Нийслэлийн гэр хорооллын хөгжлийн газарт Төслийн ахлах мэргэжилтэн

2015-2018 онуудад “Пример Инвестмент Групп” ХХК- д Төслийн удирдагч

2018-одоо “Пример Инвестмент Групп” ХХК, Гүйцэтгэх захирал

## 9. Цэнд-Аюуш БАЯРСАЙХАН

---

### *Бизнес удирдлага*

### *Боловсрол*

1987-1995 онуудад ТИС-ийн ЭХИС-ийг цахилгааны инженер

1997-1999 онуудад ТИС-ийн ИСБС-ийг магистрын зэрэг

2007-2008 онуудад Японы Нагоягийн Их Сургуулийн Материал судлалын тэнхим

- Олон улсын гагнуурын шинжээч



- Олон улсын гагнуур мэргэжилтэн

2013 онд ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн Механикжуулалтын салбар “Метал гадаргууд өндөр хурдны ширээлтээр бүрхүүл тавих боломжийн судалгаа” сэдвээр техникийн ухааны Ph.D докторын зэрэг

*Хөдөлмөр эрхлэлт*

1995-2001 онуудад ШУА-ийн Физик Технологийн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан

1999-одоо “Өөдөө Инженеринг” ХХК-ийн захирал

2009-2011 онуудад БНСУ-ийн Даэжеонг хотын Эрчим Хүчний Хүрээлэнгийн эко эрчим хүчний судалгааны төвд эрдэм шинжилгээний ажилтан

2001- 2009 онуудад ШУТИС-ийн Механик Инженерийн Сургуулийн Мехатроникийн тэнхимд багш

2015- 2016 онуудад БНСУ-ийн Жангвоны Их Сургууль, Материал судлалын тэнхим, зочин профессор

2016-одоо ШУТИС-ийн Механик Тээврийн Сургуулийн Механик, Мехатроникийн салбарт дэд профессор



**“МОН-ИТ БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурлыг зарлан хуралдуулах тухай**

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.4 дахь заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 65-р зүйлийн 65.3, 65.4 дэхь заалт, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.18 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, компанийн 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

**Нэг.** “Мон-Ит Булигаар” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 14 цагт Монгол улс, Улаанбаатар хот, ХанУул дүүрэг, 2-р хороо, Мон-Ит Булигаар ХК-ийн байранд хуралдуулсугай.

**Хоёр.** “Мон-Ит Булигаар” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.

- 2.1. “Мон-Ит Булигаар” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
- 2.2. “Мон-Ит Булигаар” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд (кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ийг 1 жилийн хугацаагаар улируулан сонгох;

**Гурав.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2020 оны 3 сарын 16-ны өдрийн дотор Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд тус тус хүргүүлсүгэй.

**Дорov.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 03 дүгээр сарын 31-ний өдрөөр тогтоосугай.

**Тав.** Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай зарыг 2020 оны 03 дугаар сарын 16-ний өдрийн дотор Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд зарлан, зарыг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан



мэдээлсүгэй. Энэхүү хурлын зарыг анх зар хүргэсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2020 оны 03 сарын 31-ний өдөр дахин зарлан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.

**Зургаа.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн тосол, түүнтэй холбоотой баримт бичгийг 2020 оны 03 сарын 21-ний өдрийн дотор үнэт цаасны брокер дилерийн компаниудад хүргүүлсүгэй.

**Долоо.** Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Б.Анхболдыг мөн хурал зохион байгуулах комиссын даргаар А.Энхмэнд, гишүүдэд Ц.Мөнхлхагва, У.Ундрах-Эрдэнэ нарыг сонгосугай.

**Найм.** Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай.

Хурлын тооллогын комиссын дарга - П.Азжаргал

Хурлын тооллогын комиссын гишүүд - Ю.Дүгэрмаа, П.Чойжилмаа

**Ес.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудасны загварыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

**Арав.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын нийтэд хүргэх зарын загварыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

**Арван нэг.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал, баримт бичгийг гуравдугаар хавсралтаар баталсугай. Энэхүү хурлын материалтай ажлын өдрийн 09-18 цагийн хооронд хувьцаа эзэмшигчид танилцах боломжийг бүрдүүлэхийг Гүйцэтгэх захирал Б.Анхболд-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА А.ЭНХМЭНД





## “МОН-ИТ БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

\_\_\_ оны \_\_\_ сарын \_\_\_ өдөр

Дугаар \_\_\_

Улаанбаатар хот

### Компаний 2019 оны үйл ажиллагааны болон Санхүүгийн тайлан батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалт, “Мон-Ит Булигаар” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020 оны 04 дугаар сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

**Нэг.** Мон-Ит Булигаар ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах.

ХУРЛЫН ДАРГА

Б.АНХБОЛД



## “МОН-ИТ БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

\_\_\_ оны \_\_\_ сарын \_\_\_ өдөр

Дугаар \_\_\_

Улаанбаатар хот

### Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 67.3.8 дахь заалт, компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд хэлэлцсэн “Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох” асуудлаар хувьцаа эзэмшигчдээс гаргасан саналыг тоолсон дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

#### **Нэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар өгсөн санал:**

1. Б.Анхболд -д нийт санал өгөх эрх .....  
санал өгсөн эрх..... хувь .....
2. Б.Баянжаргал-д нийт санал өгөх эрх .....  
санал өгсөн эрх..... хувь .....
3. Д.Гансүх-д нийт санал өгөх эрх .....  
санал өгсөн эрх ..... хувь .....
4. А.Энхмэнд-д нийт санал өгөх эрх .....  
санал өгсөн эрх..... хувь .....
5. М.Бат-Очир-д нийт санал өгөх эрх .....  
санал өгсөн эрх..... хувь .....

#### **Хоёр. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар өгсөн санал:**

1. Б.Аюуш-д нийт санал өгөх эрх .....  
санал өгсөн эрх..... хувь .....
2. Н.Батхуяг-д нийт санал өгөх эрх .....  
санал өгсөн эрх..... хувь .....
3. Н.Мягмардорж-д нийт санал өгөх эрх .....  
санал өгсөн эрх..... хувь .....
4. Ц.Баярсайхан-д нийт санал өгөх эрх .....  
санал өгсөн эрх..... хувь .....-аар

тус тус сонгогдсоныг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулан батлуулсугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.АНХБОЛД